



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/74

Шивээговь сум

Сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр
шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5, сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/15 дугаар захирамжаар батлагдсан “Сумын Засаг даргаас олгох шагналын журам”-ын 2.1.3, 5.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Тулгар төрийн 2230, 2231 жил, Их Монгол Улсын 815, 816 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, 111 жил, Ардын хувьсгалын 100, 101-н жилийн ой, сумын баяр наадмыг тохиолдуулан сум, орон нутагтаа идэвх санаачлагатай ажилласан ахмад настан Батжаргалын Бадамсамбуу, Эрүүл мэндийн төвийн сувилагч Дамчаабадгарын Болормаа, Ерөнхий боловсролын сургуулийн жижүүр Цэдэнсодномын Цолмонгэрэл, Илчлэг Шивээ аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйлчлэгч Дашдондогийн Амаржаргал, малчин Наранбатын Ганзориг нарыг Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.

2.Шагналд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 150,000 (нэг зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

4.Холбогдох ажлыг зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ), нярав (Б.Алтжин) нарт, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  П.ГАНЧИМЭГ



Сумын Засаг даргын 2022 оны 07-р сарын 07-ны өдрийн 1174 дугаар захирамжийн хавсралт



“ЖУУХ БИЧИГ” ШАГНАЛД ЗАРЦУУЛАГДАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

2022.07.01

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Засаг даргын “Жуух бичиг”				
1	Мөнгөн шагнал	5	30,000	150,000
Нийт				150,000